



ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЯАМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХРОО



МОНГОЛИИН ЗАГДАГ ДАРЫН ИЮЛСҮҮЧИЙН НӨХЦӨЛ  
БИЗНЕС ИННОВАЦ  
ХӨГЖЛИЙН ГАЗАР



USAID  
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ҮНДСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМ



# IREEE ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН, КОНФЕРЕНЦ

ИННОВАЦ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙН  
ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН, КОНФЕРЕНЦ

2024.05.16-18 | Мишээл Экспо төв

Бүртгэл дуусах хугацаа: 2024.05.03



📞 9000-6950, 9903-6193, 7727-7070/4/



ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЯАМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



НИЙСЛИЙН ЗАГАС ДАРЫН ИЮЛСҮҮГҮҮР НӨЛНӨЛ  
БИЗНЕС ИННОВАЦ  
ХӨГЖЛИЙН ГАЗАР



USAID  
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ҮНДСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМ

# ИННОВАЦ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШГИЙН ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН, КОНФЕРЕНЦ

2024.05.16-18 | Мишээл Экспо төв

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс эрчим хүчийг үр ашигтай, хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчтэй хослуулж хэрэглэхийг олон нийтэд уриалж, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхийг зорьж байна. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг буюу USAID-ийн дэмжлэгтэйгээр Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран “Инновац, Эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний олон улсын үзэсгэлэн, конференц”-ийг зохион байгуулах гэж байна. Энэхүү арга хэмжээнд Монгол Улсын эрс тэс цаг уурт хамгийн сайн тохирсон эрчим хүчний шийдлүүдийг санал болгож буй дотоод болон гадаадын компаниуд болон эрдэмтэн, судлаач нар, төрийн байгууллагын төлөөллийн хамт оролцох тул эрчим хүч хэрэглэгч таныг урьж байна.





ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЯМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХРОО



НИЙТЛЭЛИЙН ЗАГДЫН ДАРЫН ИЮНДСҮҮРЧИГ НӨВЛӨЛ  
БИЗНЕС ИННОВАЦ  
ХӨГЖЛИЙН ГАЗАР



USAID  
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ҮНДСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАХНКИМ

## ЗОРИЛГО

**Тулгарч буй сорилтыг хамтран хэлэлцэх:** Монгол Улсад эрчим хүчний хэмнэлт, үр ашиг, сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэхэд тулгарч буй бэрхшээл, сорилтуудыг төр, хувийн хэвшил, олон нийтийн төлөөлөл хамтран хэлэлцэж, тодорхойлно.

**Шийдвэр санал болгох:** Эрчим хүчний үр ашиг, хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчтэй холбогдох сүүлийн үеийн технологиуд, шинэлэг санхүүжилтийн хувилбарууд, дэлхийн бодлогын сайн туршлагаас хуваалцана.

**Оновчтой шийдвэр гаргахад нөлөөлөх:** Улс даяар эрчим хүчний үр ашиг, хэмнэлт, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд нөлөөлөх бодлогын зөвлөмжийг хамтран хэлэлцэж гаргана.

## ХҮЛЭЭЖ БУЙ ҮР ДҮН

**Олон нийтийг мэдээллээр хангах:** Зах зээл дээр байгаа сэргээгдэхийн болон эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлчилгээний тухай олон нийт болон бизнесийн байгууллагуудыг мэдээллээр хангана.

**Бодлогын оновчлол:** Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийг нэмэгдүүлэх хүрээнд тухайлбал шөнийн тариффын хөнгөлөлт, ухаалаг тоолуур нэвтрүүлэх зэрэг асуудлаар оролцогч талуудын саналыг тусгасан зөвлөмж гаргана.

**Хамтын ажиллагаа:** Монгол Улсын цэвэр эрчим хүчний шилжилтийг дотоод болон гадаадын компаниудын тусламжтайгаар хурдасгах хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.





ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЯАМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХРОО



ИМПЕРИИН ЗАГДЫН ДАРЫН ИЮЛСҮҮЧИЙН НӨХЦӨЛ  
БИЗНЕС ИННОВАЦ  
ХӨГЖЛИЙН ГАЗАР



USAID  
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ҮНДСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМ

## ХӨТӨЛБӨР

### 5 сарын 16 (Пүрэв гараг)

#### Эрчим хүчний үр ашиг: Бодлого зохицуулалтын орчин

- Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн хүрээнд Монгол Улсад хэрэгжүүлж буй ажлууд, тулгарч буй сорилтууд
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль эрх зүйн орчин
- Цахилгааны эрчим хүчний хэмнэлт: Шөнийн тарифын хөнгөлөлт
- Дулааны эрчим хүчний хэмнэлт: Хэрэглээнд сууринсан төлбөр тооцоо

### 5 сарын 17 (Баасан гараг)

#### Эрчим хүчний үр ашиг: Үүрэг хүлээсэн хэрэглэгчид

- Олон улсын (АНУ, Канад, Хятад болон бусад) болон Монголын компаниудын шинэ технологийн танилцуулга
- Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх үйлчилгээ, стандартууд
- Ногоон санхүүжилтийн боломжууд

### 5 сарын 18 (Бямба гараг)

#### Эрчим хүчний үр ашиг: Айл өрх, ахуйн хэрэглэгчид

- Барилгын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх шийдлүүд
- Барилгад сэргээгдэх эрчим хүчийг ашиглах боломжууд
- Айл өрхүүд бие даасан хэлбэрээр эрчим хүчээ хэрхэн шийдэх тухай, үүнийг дэмжих хөтөлбөрүүд





ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЯАМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХРОО



НИЙСЛИЙН ЗАГДЫН ДАРЫН ИЮНДСҮҮРЧИГ НӨЛНӨЛ  
БИЗНЕС ИННОВАЦ  
ХӨГЖЛИЙН ГАЗАР



USAID  
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ҮНДСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМ

## ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАНХИМД ДООРХИ ШИЙДЛҮҮД ТАНИЛЦУУЛАГДАНА:

- Цахилгаан, дулаан түгээх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйлчилгээг нэгдороос авах
- Эрчим хүчний үр ашигтай тоног төхөөрөмжүүд
- Эрчим хүчний хэмнэлттэй ахуйн цахилгаан хэрэгсэл
- ААН, албан байгууллага, айл өрхөд зориулсан сэргээгдэх эрчим хүчний дэвшилтэт технологиуд
- Нарны дэлгэц, цахилгаан үүсгүүр, дулааны насос, эрчим хүчний үр ашигтай цахилгаан халаагур, цахилгааны хэмнэлттэй шөнийн дулаан хадгалагч
- Халаалт, халуун ус, хөргөлт, агааржуулалтын системийн дэвшилтэт технологиуд
- Цахилгаан, дулаан, усны тоолуур
- Эрчим хүчний системийн автоматжуулалт
- Ногоон барилга
- Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдал багатай амины орон сууцны шийдлүүд
- Эрчим хүчний хэмнэлттэй барилгын материалууд, барилгын шийдлүүд
- Эрчим хүчний аудит, ОУ-ын стандарт нэвтрүүлэх үйлчилгээ
- Эрчим хүчний зураг төсөл
- Ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжууд – бохир усны орчин үеийн шийдлүүд
- Ухаалаг сүлжээ болон бусад олон техник, технологийн шийдлүүд
- Инновац нэвтрүүлсэн бүтээгдэхүүнүүд



ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЯАМ



ЭРЧИМ ХҮЧНИЙ  
ЗОХИЦУУЛАХ ХРОО



МОНГОЛЫН ЗАГАС ДАРТЫН ИЮЛСҮҮЧИЙН НӨХЦӨЛ  
**БИЗНЕС ИННОВАЦ  
ХӨГЖЛИЙН ГАЗАР**



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



МОНГОЛЫН ҮНДСНИЙ  
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН  
ТАНХИМ

Бүртгэл дуусах хугацаа: 2024 оны 5 дугаар сарын 3 дуустал

ХОЛБОО БАРИХ: МҮХАЙТ, Үзэсгэлэн яармагийн газар

Утас: 90006950, 99036193, 77277070-4

Цахим шуудан: [exhibition@mongolchamber.mn](mailto:exhibition@mongolchamber.mn)

